**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/219 Номгон

Аймгийн Онцгой комиссын
Гэрийн ажиглалтад хяналт тавих шуурхай
бүлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн $27^1$.1.6, 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай" 02, "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/216 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 30 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд шилжилт, хөдөлгөөн үйлдсэн иргэдийн хөдөлгөөний гэрийн ажиглалтад хяналт тавих зорилго бүхий аймгийн Онцгой комиссын Гэрийн ажиглалтад хяналт тавих шуурхай бүлгийг томилсугай.

2.Аймгийн Онцгой комиссын Гэрийн ажиглалтад хяналт тавих шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

1210547

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
26-ны өдрийн 219 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ГЭРИЙН АЖИГЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ШУУРХАЙ БҮЛГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Шуурхай бүлгийн дарга | Тагнуулын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн |
| Гишүүд | Цэргийн штабын дарга, Онцгой комиссын гишүүн |
| | Эрүүл мэндийн газрын Шуурхай штабын дарга |
| | Цагдаагийн газрын дэд дарга |
| | Нэгдсэн эмнэлгийн дарга |
| | Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын дарга |

_________oOo________